



АЗИ-НОМХОН ДАЛАЙ:
УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫН
ИРМЭГТ АМЬДАРЧ БУЙ
ИТГЭЛ НАЙДВАР БА ШИЙДЭЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИ ЙН НӨЛӨӨ МОНГОЛ УЛСАД

ACT!
ACTIVISTS' COALITION ON TB
ASIA-PACIFIC


APCASO
Strengthening community systems.
Advancing human rights.

ACT!MN
ACTIVISTS' COALITION ON TB MONGOLIA

МСТХ
МОНГОЛЫН СУРЬЕЭТЭЙ
ТЭМЦЭХ ХОЛБОО

ОРШИЛ

Уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, байгалийн тогтолцоо, амьдралын хэв маягт заналхийлж буй энэ цаг үеийн тулгамдсан, асуудал. Ази, Номхон далайн бүс нутаг нь Гималайн сүрлэг нуруунаас эхлэн Номхон далайн жижиг арлууд хүртэл үргэлжлэх өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарч, газарзүй, байгаль, цаг уурын хувьд онцлогтой.

Ази, Номхон далайн орнууд байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж буй бүс нутагт тооцогддог.

Зарим орнууд далайн түвшин нэмэгдэх, хар салхины давтамж, хүч нь ихсэх зэрэг эрсдэлтэй нүүр тулгарч байгаа бол нам дор газрын орнууд болон төвийн хуурай бүс нутгууд үер, ган гачигт улам өртөмтгий болж байна. Түүнчлэн энэ бүс нутагт амьдарч буй хүмүүсийн байгалийн гамшигт өртөх магадлал нь дэлхийн бусад бүсийн орнуудтай харьцуулахад зургаа дахин өндөр байгаа нь байдал хэрхэн ноцтой байдгааг илтгэж байна.

Хэдийгээр уур амьсгалын өөрчлөлт Ази, Номхон далайн бүсийн орнуудад улам бүр гүнзгийрч байгаа өнөөгийн нөхцөлд зөв шийдэл гаргаж, өөрчлөлт хийх асар их боломж бий гэдгийг онцлох нь зүйтэй.

Энэхүү бүтээлийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн уршгаар бүс нутаг дахь эрсдэлт бүлгийн иргэд хэрхэн шууд болон шууд бусаар өртөж буй бодит түүхийг өгүүлж, тэдний даван туулсан туршлага, сургамжийг олон нийтэд хүргэхэд оршино.

МОНГОЛЫН ТУХАЙ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- **Хүн ам:** 3.5 сая (2024 оны байдлаар)
- **Эдийн засаг:** Сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг гол төлөв уул уурхайн салбарт тулгуурлан хөгжиж ирсэн. 2004 оноос хойш эдийн засаг нь дэлхийд хамгийн хурдацтай өсч буй орнуудын нэгд тооцогдож, жилд дунджаар 6.3%-ийн өсөлттэй байсан нь дэлхийн дундаж 2.9%, өндөр хөгжилтэй орнуудын дундаж 1.7%-иас хоёр дахин давсан үзүүлэлт болж, дэлхийн эдийн засгийн хөгжлийн төвүүдтэй алхам алхмаар ойртсоор байна.
- **Соёл:** Нийт хүн амын 40 гаруй хувь нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг бөгөөд хүн амын гуравны нэг нь гэрт амьдардаг. Гэрийг харьцангуй хялбар барьж, нүүлгэх боломжтой, байгаль орчинд ээлтэй, өвөрмөц сууц бөгөөд Монголчуудын соёл, уламжлал, амьдралын хэв маягийн салшгүй нэг хэсэг билээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ: СҮРЬЕЭ

- **Шинэ тохиолдлын түвшин:** 100,000 хүнд 428.
- **Хүүхдийн сүрьеэ:** Шинэ тохиолдлын 11%-ийг хүүхдийн сүрьеэ эзэлж байгаа нь дэлхийн дундаж 7% болон бүсийн дундаж 3%-аас өндөр үзүүлэлт юм.

УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛ:

- **Дэлхийн эрсдэлийн индекс:** Монгол Улс уур амьсгалын өндөр эрсдэлтэй орны тоонд багтдаг ба ган болох эрсдлээрээ дэлхийд 27-д эрэмбэлэгддэг.
- **Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө:** Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.1°C-ээр нэмэгдсэн нь хөдөө аж ахуй болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Өвлийн улиралд 11-р сараас 2-р сарын хооронд нийслэл Улаанбаатар хотын температур -40°C-ээс доош болох тохиолдол элбэг тохиолддог.

Хотын иргэн болон Архангай аймгийн Жаргалант сумын малчны бодит түүх



Сүүлийн жилүүдэд Монгол Улс түүхэнд байгаагүй тэсгим хүйтэн өвлүүдийг туулж, агаарын температур түүхэн доод түвшинд хүрчээ.

Улаанбаатар хотод амьдардаг 2 хүүхдийн эх Түмээд ханиалгах, толгой өвдөх зовиур байнга илэрдэг байжээ. Энэ нь олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС)-ийн үед илрэх шинж тэмдэг байв. ОЭТС нь сүрьеэгийн эсрэг нэгдүгээр эгнээний эмэнд тэсвэртэй болсон микобактер туберкулосис омгийн нянгаар үүсгэгддэг. Түмээд ядарч сульдах, цээжээр хөндүүрлэх зовиур илэрсээр уджээ.

"Өдөр ирэх тусам улам л хүйтэрч байна. Энэ үеэр ийм тэсгим хүйтэн байдаггүйсэн. Энэ жилийн өвөл өмнөхөөс хавьгүй удаан үргэлжилж байна."

Түүний биеийн байдлыг улам дордуулах шиг хаврын улирал айлчлан ирэх 3 дугаар сарын үеэр хотод шороо тоос, утаа униар ихсэх нь түүний өвчнийг сэдрээж гадаа гарч, цээж дүүрэн амьсгалахад хүндрэлтэй болгодог ажээ.

"Гадуур чөлөөтэй явах ямар ч боломж алга" гэж тэр хэлэв. Хот нь ногоон байгууламж муутайн дээр нүүрс, машины утаа зэргээс шалтгаалан агаарын бохирдол ихтэй байдаг байна.

Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 400 километрт Архангай аймгийн Жаргалант суманд Бямбаагийн Гончигхандынх байдаг.

"Малчдын хувьд эрдэнэт мал, эд хөрөнгө нь амьдарлын утга учир" гэж нэр хүндтэй малчин, хүний эрхийн төлөө тэмцэгч Гончигханд хэлэв.

"Ердөө ганцхан улирлын дотор манай гэр бүл бүх зүйлээ алдсан, энэ нь бидэнд сэтгэлзүйн хувьд хүнд цохилт болсон. Хөөрхий ээж минь сэхэл авч чадаагүйдээ, энэ явдал ядуурал, сэтгэл гутралд оруулж, бидний бусад бүх зүйлийг минь авсандаа" гэж тэрээр гунигтай ярих.

Тэрээр Түмээгийн хэлснийг давтан цаг агаар хурдацтай өөрчлөгдөж байгаа тул малчид хүртэл урьдчилан таамаглаж, бэлтгэл базаах боломжгүй болсон гэв.

"Би уур амьсгалын өөрчлөлтийн талаар өмнө хэзээ ч эрэгцүүлэн боддоггүй байжээ. Малчдын хувьд ийм зүйл болж л байдаг гэж боддог байв... Гэвч энэ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө байжээ..."

“ХӨХ ТЭНГЭР”-ИЙН ОРОН

Зүүн Азийн төвд орших, далайд гарцгүй Монгол Улс уудам хээр тал, хуурай цөлөөрөө алдартай. Жилд дунджаар 250 өдөр нартай байдаг тул “мөнх хөх тэнгэрийн орон” гэж нэрлэдэг. Хэдий өргөн уудам нутагтай ч Монгол Улс хүн амын нягтрал хамгийн багатай. Одоогийн Монголчуудын дунд уламжлалт мал аж ахуй, нүүдэлчин амьдралын хэв маягаа хадгалаж буй хүмүүс олон байдаг.

Монгол Улс нь хүний хөгжлийн зарим үзүүлэлт тухайлбал, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлалт, бага боловсролын түвшин харьцангуй өндөр орнуудын нэг юм. Гэвч хурдтай хөгжиж буй хотжилтын нөлөөгөөр нийгэм, эдийн засгийн өнгө төрх нь эрс өөрчлөгджээ. 2019 оны байдлаар хүн амын 68.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрч, хот руу чиглэсэн хүн амын шилжилт эдийн засгийн боломжийг нэмэгдүүлсэн ч, нийгмийн тулгамдсан асуудлуудыг дагуулсаар байна.

Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй орнуудын нэгд тооцогддог. Дэлхийн банкны 2024 онд гаргасан “Улс орны уур амьсгал ба хөгжлийн тайлан”-д Монгол Улсыг дэлхийн дулааралд хурдацтай автаж, иргэдийн аж амьдрал, амьжиргаанд нь сөргөөр нөлөөлж байгаа талаар дурдсан байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улс олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож эхэлсэн. Тухайлбал, 2016 онд Парисын хэлэлцээрийг соёрхон баталсан, мөн 2018 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд 3 дахь тайлангаа илгээж, 2020 онд “Өөрийн орны санаачилгаар хувь нэмэр оруулах баримт бичиг”-ээ шинэчилсэн. Эдгээр алхам нь Уур амьсгалын ногоон сан зэрэг олон улсын санхүүжилт, техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдах үүд хаалгыг нээсэн юм.

Монгол Улс дотооддоо уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” 2011–2021, “Ногоон хөгжлийн бодлого” 2014–2030 зэрэг олон бодлогын баримт бичгийг баталсан. Эдгээр бодлогын нэг чухал хэсэг нь эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, халаалтын системийг дэмжих юм. Цаашилбал, хатуу ширүүн өвлийн улирлыг давахад туслах байгальд ээлтэй дулаалга, сайжруулсан зуух, нар, салхины эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг түлхүү нэвтрүүлэн нүүрсний хэрэглээг бууруулах зорилготой.

Хэдий хүчин чармайлт гаргаж байгаа ч Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нийгмийн эрүүл мэндийн асуудлуудтай нүүр тулсаар байна. Тухайлбал, сүрьеэгийн тохиолдлын түвшин 100,000 хүн амд 428 байгаа нь Номхон далайн баруун бүсийн хэмжээнд сүрьеэгийн дарамт өндөртэй орнуудын нэгд тооцогддог. Хамгийн санаа зовоох асуудал нь, сүрьеэгийн шинэ тохиолдлын дунд хүүхдийн сүрьеэгийн эзлэх хувь 11% байгаа нь дэлхийн дундаж 7%, бүсийн дундаж 3%-тай харьцуулахад асар өндөрт тооцогдож байна.

100,000 хүн амд ОЭТС-ийн 83 тохиолдол байгаа нь Монгол Улсыг ОЭТС-ийн дарамт өндөртэй 30 улсын жагсаалтад оруулсан. Гэхдээ, урт хугацааны эмчилгээ шаарддаг энэ өвчний эмчилгээний амжилт мэдрэг сүрьеэгийн хувьд 90%, ОЭТС-ийн хувьд 70% байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. Түмээгийн хувьд ОЭТС-тэй сүүлийн 7 жилийн турш нүүр тулж явна.

Улаанбаатарын уугуул, хувиараа хөдөлмөр эрхлэгч тэрээр энэ өвчинд өртсөн олон хүмүүсийн нэг. 2018 онд оношлогдсон цагаас эхлэн түүний амьдрал бүрэн өөрчлөгдсөн. Тэрээр 3 жилийн хугацаанд алдаг оног улсаас тэтгэмж авч байсан ч нийгэм хамгааллын асуудлаар олон зүйлийг өөрчлөх хэрэгтэй гэж тэр боддог.



Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй **нийгмийн эрүүл мэндийн асуудлуудтай** нүүр тулсаар байна. Тухайлбал, сүрьеэгийн шинэ тохиолдлын түвшин 100,000 хүн амд 428 байгаа нь **Номхон далайн баруун бүсийн хэмжээнд сүрьеэгийн дарамт өндөртэй** орнуудын нэгд тооцогддог



Байнга л ханиад хүрч байдаг охин нь сургуулийн солилцооны хөтөлбөрт хамрагдан Германы Франкфурт хотод очоод нэг зүйлийг анзаарчээ. Ердөө хоёр хоногийн дотор ханиалга нь ул мөргүй арилсан байна. Түмээ охиндоо хөтөлбөрийн хугацаанд хэрэглэх эмийг нь өгч явуулсан боловч эмээ бүгдийг хэрэглээгүй нь аваад иржээ. Эндээс л тэр цэвэр агаар ямар чухал болохыг ойлгожээ. Түмээ Улаанбаатар хотыг ногоон байгууламж, модоор хүрээлэгдсэн, иргэдээ өвчлүүлдэггүй, цэвэр агаартай байсан ч болоосой гэж хүсдэг.

“Цэвэр агаар бол хүний бие хамгийн хэрэгтэй эм юм даа” ... Гадуур явахад маск зүүж, ороолтоор амаа дарахаас өөр аргагүй байдаг тухайгаа тэрээр нэмж

хэлэв. Түмээгийн энэ үйлдэл нь зүгээр нэг сүржигнэл биш, Улаанбаатар хот агаарын бохирдлын түвшнээр ялангуяа, өвлийн улиралд дэлхийд тэргүүлэгч хотуудын нэг юм. Улаанбаатарын агаарын бохирдлын гол эх үүсвэрүүд нь нарийн ширхэгт тоосонцор (PM10, PM2.5), хүхрийн давхар исэл (SO2) болон азотын давхар исэл (NO2) гэж Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ)-ийн тайланд дурджээ.

Энэхүү тайланд нарийн ширхэгт тоосонцорын (PM10, PM2.5)-ийн агууламж үндэсний болон ДЭМБ-ын зөвшөөргдөх хэмжээнээс тогтмол давсан байдгийг дурьджээ. Хэдийгээр сүүлийн жилүүдэд агаарыг бохирдуулагчид тодорхой хэмжээнд буурсан нь ажиглагдсан ч, нүүрсний хэрэглээ нэмэгдэх үед бохирдлын түвшин дахин аюултай хэмжээнд хүрч байгааг судалгаанууд харуулжээ. Хүхрийн давхар исэл (SO2)-ийн хэмжээ ч мөн адил зөвшөөрөгдөх хэмжээг давсан хэвээр байна.

Монголын Сүрьеэтэй Тэмцэх Холбооны судалгаа, инновацын удирдагч, доктор

Ц.Базаррагчаа агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх ноцтой нөлөөний талаар онцолж байна.

“Агаарын бохирдол ба амьсгалын замын өвчний өвчлөл ялангуяа сүрьеэ нь хамааралтайг НЭМҮТ-ийн тандалт харуулж байна. Сүрьеэгийн нийт тохиолдлын 60 орчим хувь Улаанбаатар хотод бүртгэгддэг, гэтэл агаарын бохирдол хотод хамгийн их байна”

Ахмад настангуудаас гадна хүүхдүүд сүрьеэгийн эрсдэлт бүлэгт ордог. Монгол Улсад хийсэн нэгэн урт хугацааны судалгааны дүнд нүүрс түлж байгаа айл өрхийн дотоод агаарын бохирдол нь хүүхдийн өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлж, уушгины хатгалгаа өвчнөөр өвчлөх, өсөлт хоцролт, танин мэдэхүйн саатал зэрэгт хүргэдэг болохыг тогтоожээ.

“Хүүхдүүд төрсөн цагаасаа л агаарын бохирдолд өртөж байна. Бидний судалгаагаар долоон сартайгаас эхлэн уушгины хатгалгааны эрсдэл нэмэгдэж байгаа ба агаарын бохирдол хүүхдийн хөгжилд нөлөө үзүүлж байна” гэж судалгааны багийн гишүүн Ц.Базаррагчаа онцлон тэмдэглэв.

Сүрьеэгийн дарамт өндөртэй орнуудад хүүхдийн сүрьеэг оношилгоо бэрхшээлтэй хэвээр байна. Үүнд оношилгооны тоног төхөөрөмжийн хоцрогдол, мэргэшсэн эмчийн хомсдол зэрэг нөлөөлдөг. Үүнийг шийдвэрлэхийн тулд “Хүүхдийн сүрьеэг оношлох цээжний рентген зургийн атлас” гарын авлагыг Сүрьеэ уушгины өвчитэй тэмцэх олон улсын холбоо (The Union) боловсруулсан.

Монголын Сүрьеэтэй тэмцэх холбоо санаачлан Монголын Радиологийн нийгэмлэгтэй хамтран уг гарын авлагыг 2021 онд монгол хэлнээ орчуулжээ. АУ-ны доктор Ц.Базаррагчаа орчуулга болон сургалтыг удирдан зохион байгуулж, тус сургалтанд



Улаанбаатар хот нь ялангуяа өвлийн улирлын **агаарын бохирдлын түвшнээр дэлхийд тэргүүлэгч хотуудын нэг**. Агаарын бохирдлын үзүүлэлтүүд үндэсний болон ДЭМБ-ын зөвшөөрөгдөх хэмжээнээс **тогтмол өндөр байдаг**.



90 гаруй хүүхдийн болон сүрьеэгийн эмч нар хамрагдсан. Эмч нарын дунд явуулсан асуулгаар сургалтанд хамрагдсан эмч нарын 78 хувь нь уг гарын авлагыг өдөр тутмын ажилдаа үр ашигтай ашиглаж байгаагаа илэрхийлсэн байна. Эмч нар уг гарын авлагыг хүүхдийн сүрьеэг оношлох, цээжний рентген зургийг унших, эмнэлзүйн шийдвэр гаргах үйл явцад бодит дэмжлэг үзүүлж байгааг онцолжээ.

ЗУДЫН ҮР ДАГАВАР

Монголын хөдөө орон нутгийн хүн амын ихэнх хэсгийг бүрдүүлдэг малчид дотоод орчны бохирдолд бага өртдөг ч, гадаад орчны эрсдэлд өртөх нь илүүтэй байсаар байна.

2023 оны өвөл Монголд зудын аюулт үзэгдэл болж 6 сая гаруй мал хорогдсон. Харин 2024 онд байдал улам дордож, малын хорогдол 8.1 саяд хүрч, жил бүр дунджаар 200,000 орчим малчин зудын гамшигт өртдөг байна.

“Зуд бол зөвхөн малчдын хувьд эдийн засгийн алдагдал биш. Энэ бол хоол хүнсний аюулгүй байдлын томоохон сорилт юм”. “Малаа алдсан өрхүүд орлогын эх үүсвэргүй болж, хот руу нүүж ирдэг. Гэвч хотод тогтмол ажил олоход хүндрэлтэй”

Гончигханд ч энэ зовлонг туулсан олон малчдын нэг юм.

“Хэдхэн сарын дотор бүхнээ алдсан, зөвхөн малаа биш, хөрөнгөө, нэр төрөө, хоол хүнсээ хамтад нь алдсан. Энэ бүхнээс үүдэлтэй сэтгэлийн шарх хэзээ ч бүрэн эдгэрдэггүй” гэж тэр ярьжээ.

“Миний эгч өнгөрсөн жил бараг тал малаа алдсан. Бид чадах бүхнээ хийсэн ч, яаж ч чадаагүй ээ” хэмээн Гончигханд нэмж хэлэв.

Малын хорогдлоос гадна эдийн засгийн дарамт, сэтгэлийн шаналал, амьжиргаагаа алдсан малчдын дунд сэтгэл түгших эмгэг, сэтгэл гутрал нэмэгдэж байна.

Нүүлгэн шилжүүлсэн иргэдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн асуудал түгээмэл байгааг судлаачид цохон тэмдэглэсэн. “Эдгээр иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг бодлогоор нэн даруй шийдвэрлэхгүй бол уур амьсгалын өөрчлөлт нэмэгдэх тусам энэ асуудал улам гүнзгийрэх аюултай” гэж АУ-ны доктор Ц.Базаррагчаа хэлэв.

Гончигхандын хувьд эдгээр бэрхшээл түүний амьдралын талаарх үзэл бодлыг эрс өөрчилжээ. Түүний эгч, тэр 2 тогтвортой ирээдүйг бий болгоход боловсрол чухал хэмээн үзэж, мал аж ахуйгаас өөр боломжийг эрэлхийлсэн байна. Гончигханд өдгөө хувийн шалтгаанаар Ирланд улсад амьдарч байгаа ч, эгч нь гэр бүлтэйгээ Монголдоо амьдарч байна.

Гэрээсээ яваад уур амьсгалын өөрчлөлт зөвхөн Монголын асуудал биш, дэлхийн хэмжээний томоохон бэрхшээл гэдгийг ойлгож, уугуул иргэд уур амьсгалын өөрчлөлтөд илүүтэйгээр өртөж байгааг анзаарчээ. Хөгжил өндөртэй орнууд уур амьсгалын өөрчлөлтөд хариуцлагатай хандаж, зохистой тусламж, дэмжлэг үзүүлэх ёстой.

“Би очоод тэдэнд ингэж заана” гэж хэзээ ч битгий бод. Энэ бол колончлолын сэтгэлгээ” гэж Гончигханд хэлээд малчдад амьдарлын хэв маягаа өөрчил гэж гадны хүн ирээд хэлэхэд айдас төрдөг тухайгаа хүүрнэсэн юм.



Зуд бол малчдын хувьд зөвхөн эдийн засгийн алдагдал биш. Энэ бол **хүнсний аюулгүй байдлд тулгарах бэрхшээл** юм. Малаа алдсан өрхүүд орлогын эх үүсвэргүй болж, хот руу нүүдэг. Гэвч хотод **тогтмол орлоготой ажилд ороход хүндрэлтэй** байдаг.



“Гадаадын тусламжийн гол зорилго нь малчид өөрийнхөө нутагт амьжиргаагаа тогтвортой хадгалах нөхцөл бүрдүүлэхэд чиглэх ёстой” гэж Гончигханд тодотгон хэлэв.

“Уугуул иргэд өөрсдийн амьдралын нөхцөлийг хамгийн сайн мэддэг. Тэдэнд хэрэгтэй байгаа зүйл бол зөвхөн урт хугацааны, тогтвортой дэмжлэг юм”

БОДИТОЙ ТУСЛАМЖ, ҮР ДҮНТЭЙ БОДЛОГО, ЗӨВ ШИДЭЛ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

2023 оны зудын үеэр Монгол Улсын Засгийн газар хэд хэдэн аймагт онц байдал зарлаж, зудын гамшигт нэрвэгдсэн малчдад өвс, тэжээл, мөнгөн тусламж олгосон.

Гэвч зудын гамшгийн цар хүрээ асар өргөн байсны улмаас тусламжийн бараа бүх газарт цаг алдалгүй хүрэхэд хүндрэлтэй байв. НҮБ, Улаан Загалмай, Улаан Хавирган Сар зэрэг олон улсын байгууллагууд ч хөдөөгийн иргэдийн амьжиргааг хамгаалахад дэмжлэг үзүүлж, яаралтай тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Хот, хөдөөгүй хүрээлэн буй орчны доройтол бодит аюул болжээ. Монголын нийт газар нутгийн 70 гаруй хувьд нь бэлчээрийн даац хэтэрсэн, ой мод устаж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр цөлжилтөд өртсөн.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхээр 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод” үндэсний санаачилгыг эхлүүлж, 2030 он гэхэд тэрбум мод тарих зорилт тавьсан.

2022 оны сүүлээр 16 сая гаруй мод суулгасан бөгөөд уг санаачилга нь зөвхөн ойжуулалт хийгээд зогсохгүй, олон нийтийн боловсролыг дэмжих, ажлын байр бий болгох, газрын тогтвортой менежментийг сайжруулахаар зорьж байна.

2024 оны 12 дугаар сард агаарын бохирдлыг бууруулах иргэдийн шаардлагыг Монгол Улсын Их хурал хүлээн авч Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос утааны эсрэг ерөнхий хяналтын сонсголыг хийх шийдвэрийг 2024 оны 12 сарын 19-ны өдөр гаргасан.

УИХ дахь ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 2 дугаар сард “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр зохион байгуулж, УИХ-ын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн ахлан ажиллав. Тус сонсголоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (2017–2020)-ийн хүрээнд тусгагдсан арга хэмжээний 32.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 23.1 хувь нь огт хэрэгжээгүй, харин 44.7 хувь нь хангалтгүй хэрэгжсэн болохыг тэмдэглэсэн. Түүнчлэн, хэрэгжилтийн хяналт сул, салбар хоорондын уялдаа холбоо дутагдалтай байсныг ч онцлон дурджээ.

Ийнхүү тодорхой санаачлага, эерэг эхлэл байгаа ч уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг биеэр, гэр бүлээрээ туулж буй Түмээ, Гончигханд нар шиг олон хүнд илүү бодитой, үр дүнтэй арга хэмжээ хэрэгтэй байгааг доктор Базаррагчаа ч мөн дэмжиж байна.



“Бидэнд хүчтэй бодлого, шуурхай хариу арга хэмжээ, дэлхий нийтийн хамтын хүчин чармайлт шаардлагатай байна. Манай ард иргэдийн эрүүл мэнд, амьдралын чанар үүнээс хамаарч байгаа юм,”

*АУ-ны доктор Цогтын Базаррагчаа
Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо*



Эх сурвалжууд:

1. Эрүүл мэндийн яамны харьяа Халдварт өвчин судлалын үндэсний төв. 2025. "Хүрээлэн буй орчны тандалт (2018–2024)." [<https://tandalt.mn/>]
2. С. Цэгмэд, Д.Отгонбаяр, Л. Баянжаргал, Д. Өнөрбат, Ц. Базаррагчаа, С. Өнөрсайхан 2024. "Агаарын бохирдол ба Улаанбаатар хотын сүрьеэгийн өвчлөл хоорондын хамаарал." Илтгэлийн хураангуй. Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, №04 (117), Улаанбаатар.
3. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сүрьеэгийн тандалт, судалгааны алба. 2020. "Сүрьеэгийн тандалтын тайлангийн эмхэтгэл (2015–2019)." Улаанбаатар.
4. А. Ням-Өлзий "Агаарын бохирдлын асуудлаар сонсгол хийхээр боллоо." 2024 оны 12-р сарын 24. [ikon.mn](https://ikon.mn/n/3ba0) мэдээ. [<https://ikon.mn/n/3ba0>]
5. Дай З., Вулли К.Э., Дикинсон-Крейг Э., Т. Баяндорж, Н. Гомбожав, Ц. Базаррагчаа, Варбуртон Д., Томас ГН., Манасеки-Холланд. 2024. "Монгол Улсад гэр доторх агаарын бохирдол болон хүүхдийн эрүүл мэндийн хамаарлыг үнэлэх нь: төрсөн цагаас хойших судалгаа." Scientific Reports сэтгүүлд хүргүүлсэн.
6. Бодлогын судалгааны төв. 2024 оны 12-р сарын 26. "2023-2024 оны дараалсан зудын Монгол улсын мал аж ахуйн салбарт үзүүлсэн нөлөөллийг үнэлэв." [<https://www.cpr.mn/?p=913>]
7. Б. Лхагвасүрэн, Хирамото Т., Э. Бат-Эрдэнэ, болон бусад. 2024. "Монгол Улсын хүн амын дунд сэтгэл түгших, сэтгэл гутрал, тархины хэт ачааллын судалгаа." Scientific Reports, 14: 2484 (2024). [<https://www.nature.com/articles/s41598-024-52779-w>]

Энэ ажлыг APCASO, Ази Номхон далайн сүрьеэтэй тэмцэх эвсэл (АСТ!АР) болон Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо хамтран Глобал сангаас санхүүгийн дэмжлэгтэй хийж гүйцэтгэсэн болно.



APCASO нь Ази Номхон далайн бүсийн иргэний нийгмийн сүлжээ байгууллага бөгөөд Ази, Номхон далайн бүсийн эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэнд, нийгмийн шударга ёс, хүний эрх, олон нийтийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хөшүүрэг бүхий платформ юм.

Юм www.apcaso.org

Тайланд Улс, Бангкок хот 10110ь
Ватана, Клонгтон Нэү, 33-р
цамхаг 66/5, Сүхүмвит 33-р зам



Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо нь Монгол Улсад сүрьеэг устгах ажилд судалгаа, олон нийтийн оролцоо, чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан хувь нэмрээ оруулж буй иргэний нийгмийн байгууллага юм.

Монгол Улс, Улаанбаатар хот 13345,
Баянзүрх дүүрэг, 4-р хороо, энх
тайвны өргөн чөлөө 61А

Боловсруулсан баг:

Эмхэтгэсэн **Никай де Гузман, Ана П.Сантос**
Зохицуулагч **Мангала Намасивям**
Эх бэлтгэл (Англи хувилбар) **Рей Нептомос**

Монгол хэл дээр бэлтгэсэн баг:

Хянан тохиолдуулсан **Ц.Базаррагчаа**
Эх бэлтгэл, орчуулга **М.Ганзориг**
Орчуулга **Х.Даваажав**

Нүүр хуудасны зураг: Мишель Арно

3-р хуудас: Шантал де Брюйне

5-р хуудас: Пис Тунгиттипокай

7-р хуудас: Нина Майклс

9-р хуудас: Пьер Жан Дуриу

11-р хуудас: М.Ганзориг